

Нийгэм судлал 11-р анги

1. Дараах үзэгдэл ажилгүйдлийн аль хэлбэрт хамаарах вэ? Цэгийн оронд хариултаа бичээрэй

- A. Нийт үйлдвэрлэлийн хэмжээ эрс буурснаас ажлаас халагдахад хүрсэн.
- B. Энэ улирлаас үслэг эдлэл эрэлтгүй болсон тул компани ажилчдаасаа халав.
- C. Аав нь хөдөө уурхайд ажиллах болсон тул ээж нь ажлаасаа гарсан.

2. Зөв харгалзууларай.

Валютын хөвөгч ханш		Валютын ханш нь гадаадын мөнгөний эрэлт, нийлүүлэлтээр тодорхойлогдож байдаг бөгөөд ханш нь чөлөөтэй өсөж, буурч байж болно.
Валютын тогтмол ханш		Төв банк өөрийн валютын нөөцөөс зардал гарган валютыг худалдан авна.
Валютын девальваци		Чөлөөтэй өсөж буурдаггүй валютын ханш
Валютын интервенц		Төв банкнаас валютын арилжааны ханшийг өсгөх
Валютын ревальваци		Валютын тогтсон өртгийг төрөөс бууруулах

3. “ Ургац муутай жил үр тарианы үнэ өсөх, нефтийн үнэ өсөхөд бараг бүх бүтээгдэхүүний үнэ дагаж өсдөг нь бидний өдөр тутмын амьдралд мэдрэгддэг бол энэ нь аль инфляци вэ? ”

- A. Эрэлтийн инфляци
- B. Зардлын инфляци
- C. Гипер инфляци
- D. Мөлхөө инфляци

4. Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор мөнгөний хэмжээ болон зээлийн хүүд нөлөөлөхийг..... бодлого юм.

5. Эдийн засгийн тогтолцоог нөхөж бичээрэй.

Бүхий л бараа үйлчилгээний үнэ тарифийг улс тогтоодог бөгөөд ямар ч эрэлт нийлүүлэлтийн хууль үйлчилдэггүй. /...../. Хувийн улсын хувь нийлүүлсэн өмчийн аль аль хэлбэр нь байж болно. Хамгийн гол нь хувийн өмч /...../. Бодит байдалд ийм эдийн засгийн тогтолцоо нь цэвэр капитализм ба захиргаадалтын эдийн засгийн хоорондын маягтай байдаг. Хувийн өмчтэй зах зээлийн тогтолцоо, нийтийн өмчтэй төвлөрсөн төлөвлөлт дээр суурилсан тогтолцооны аль альных нь үүргийг гүйцэтгэдэг. /...../. Эдийн засгийн сул хөгжилтэй олонхи орнуудад уламжлалт буюу туршлага зан заншил уламжлалдаа тулгуурласан эдийн засгийн тогтолцоо үйлчилж байна /...../